



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр сумын Гуравдугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2026/169/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр хот

2026 он

Өвөрхангай аймгийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargal@audit.gov.mn
Аудитын менежер: П.Хорлоосүрэн
Утас: 99163491 Цахим хаяг: Khorloosuren.audit@gmail.com
Утас: 70323108 Цахим хаяг:
Аудитор: Ж.Алтанцэцэг
Утас: 99329182 Цахим хаяг: altaaj97@yahoo.com
Аудитыг гүйцэтгэсэн: Дөлгөөнхайрхан уул аудит ХХК

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

АРВАЙХЭЭР СУМЫН ГУРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

Ддб. Ол. дЗ № 118
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар цэцэрлэг нь тайлант онд улсын төсвөөс 683.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 76.2 сая төгрөг, татварын бус орлогоор 4,0 сая төгрөг бүгд 763.9 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулснаас 72.1 хувь буюу 647.7 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулжээ. Тайлант онд 24,181.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Арвайхээр сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 12/03 тоот тогтоолоор 1,975.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж 727.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталж хөрөнгийн бүртгэлд тусгасан байна. Мөн элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглах жил, үнийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн тогтоож аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/15 тоот тушаалаар нийтийн эзэмшлийн 4.2 сая төгрөгийн, 4 нэр төрлийн 5.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 7,7 сая төгрөгийн тавилга, эд хогшилд дахин үнэлгээ хийж орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн

6025020282
D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт төсөл, 52 арга хэмжээ төлөвлөж 92 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>253427649.86</u>	<u>94305229.10</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	184602894.86	26254536.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	184602894.86	26254536.10
3121	Төгрөг	184602894.86	26254536.10
31211	Төрийн сангийн харилцах	184602894.86	26254536.10
35	БАРАА МАТЕРИАЛ	68824755.00	68050693.00
354	Хангамжийн материал	68824755.00	68050693.00
35410	Бичиг хэргийн материал	38500.00	99000.00
35460	Хүнсний материал	3869280.00	3378960.00
35470	Бусад хангамжийн материал	64916975.00	64572733.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>502050964.04</u>	<u>511844988.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	502050964.04	511844988.95
392	Биет хөрөнгө	436500964.04	446474988.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	411787277.44	426987277.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70910905.92	-84170466.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50722874.00	60141004.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13576251.76	-17478487.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24661125.00	22969866.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18832723.36	-6510073.48
39209	Зам, гүүрийн байгууламж	27000000.00	27000000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-9675000.00	-12375000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	46649000.00	40529000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11907331.36	-11201030.68
39217	Ном	582900.00	582900.00
393	Биет бус хөрөнгө	65550000.00	65370000.00
39301	Програм хангамж	900000.00	900000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-510000.00	-690000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	65160000.00	65160000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>755478613.90</u>	<u>606150218.05</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>389950.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	389950.00
413	Өглөг	0.00	389950.00
4136	Бусад өглөг	0.00	389950.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	389950.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>755478613.90</u>	<u>605760268.05</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	755478613.90	605760268.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	270796062.00	270796062.00
51101	Өмч: - төрийн	270796062.00	270796062.00
512	Хуримтлагдсан үр дүн	283932839.18	134214493.33
51210	Өмнөх үеийн үр дүн	154527864.82	283932839.18
51220	Тайланг үеийн үр дүн	129404974.36	-149718345.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200749712.72	200749712.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>755478613.90</u>	<u>606150218.05</u>

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	956802100.00	787195400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40280500.00	27310000.00
120	Нийтлэг татварын бус орлого	40280500.00	27310000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4379000.00	4000000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4000000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4379000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	33091500.00	23310000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2810000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916521600.00	759885400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	854979400.00	683643200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	854979400.00	683643200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61542200.00	76242200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61542200.00	76242200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	827397125.64	936913745.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	827397125.64	936913745.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	807023379.64	929395966.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549107977.63	647670952.21
210101	Үндсэн цалин	374014759.63	423357671.49
210102	Нэмэгдэл	142131578.00	167425552.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	20847540.00
210104	Урамшуулал	32961640.00	36040188.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68114882.83	77978066.55
210201	Тэтгэврийн даатгал	46524219.39	53212582.16
210202	Тэтгэмжийн даатгал	5549976.02	6350976.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2906810.52	3232938.47
210204	Ажилгүйдлийн даатгал	2502777.42	3044418.11
210205	Эрүүл мэндийн даатгал	10631099.48	12137151.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48076754.00	52748421.00
210301	Гэрэл, цахилгаан	6464065.00	8627069.00
210302	Түлш, халаалт	35242133.00	35242200.00
210303	Цэвэр, бохир ус	6370556.00	8879152.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16062242.00	10055872.00
210401	Бичиг хэрэг	8093400.00	4741760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5592360.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	2376482.00	5314112.00
2105	Нормативт зардал	75104590.00	81524940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1391560.00	993680.00
210502	Хоол, хүнс	73713030.00	80531260.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9304000.00	8933650.00
210604	Урсгал засвар	9304000.00	8933650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	1316000.00	3404000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1316000.00	3404000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39936933.18	47080065.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8093400.00	6845560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2536600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31843533.18	37697905.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20373746.00	7517779.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16708300.00	4024000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16708300.00	4024000.00

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	3665446.00	3493779.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3665446.00	3493779.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	129404974.36	-149718345.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	129404974.36	-149718345.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	916521600.00	763885400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	4000000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	4000000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	4000000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916521600.00	759885400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	854979400.00	683643200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	854979400.00	683643200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61542200.00	76242200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61542200.00	76242200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	804713110.46	898051828.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	804713110.46	898051828.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	784339364.46	890534049.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549107977.63	647670952.21
210101	Үндсэн цалин	374014759.63	423357671.49
210102	Нэмэгдэл	142131578.00	167425552.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	20847540.00
210104	Урамшуулал	32961640.00	36040188.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68114882.83	77978066.55
210201	Тэтгэврийн даатгал	46524219.39	53212582.16
210202	Тэтгэмжийн даатгал	5549976.02	6350976.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2906810.52	3232938.47
210204	Ажилгүйдлийн даатгал	2502777.42	3044418.11
210205	Эрүүл мэндийн даатгал	10631099.48	12137151.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48076754.00	52748421.00
210301	Гэрэл, цахилгаан	6464065.00	8627069.00
210302	Түлш, халаалт	35242133.00	35242200.00
210303	Цэвэр, бохир ус	6370556.00	8879152.00
2105	Нормативт зардал	75781050.00	80040940.00
210502	Хоол, хүнс	75781050.00	80040940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9800000.00	9000000.00
210604	Урсгал засвар	9800000.00	9000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1316000.00	4369300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1316000.00	4369300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32142700.00	18726370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23741300.00	13819570.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8401400.00	4906800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20373746.00	7517779.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16708300.00	4024000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16708300.00	4024000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	3665446.00	3493779.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3665446.00	3493779.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	111808489.54	-134166428.76
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3160000.00	24181930.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3160000.00	24181930.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3160000.00	24181930.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3160000.00	24181930.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3160000.00	-24181930.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	108648489.54	-158348358.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	75954405.32	184602894.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	184602894.86	26254536.10

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дун	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	270,796,062.00	200,749,712.72	154,527,864.82	0.00	626,073,639.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,796,062.00	200,749,712.72	154,527,864.82	0.00	626,073,639.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	129,404,974.36	0.00	129,404,974.36
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,796,062.00	200,749,712.72	283,932,839.18	0.00	755,478,613.90
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	270,796,062.00	200,749,712.72	283,932,839.18	0.00	755,478,613.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	270,796,062.00	200,749,712.72	283,932,839.18	0.00	755,478,613.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-149,718,345.85	0.00	-149,718,345.85
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	270,796,062.00	200,749,712.72	134,214,493.33	0.00	605,760,268.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	992475900.00	807873110.46	930633400.00	911233758.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	992475900.00	807873110.46	930633400.00	911233758.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975767600.00	787499364.46	926609400.00	903715979.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	703064000.00	549107977.63	650023400.00	647670952.21
210101	Үндсэн цалин	505796800.00	374014759.63	434537100.00	423357671.49
210102	Нэмэгдэл	182558200.00	142131578.00	190352100.00	167425552.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт		0.00	0.00	20847540.00
210104	Урамшуулал	14709000.00	32961640.00	25134200.00	36040188.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80789500.00	68114882.83	80845700.00	77978066.55
210201	Тэтгэврийн даатгал	54938600.00	46524219.39	54844600.00	53212582.16
210202	Тэтгэмжийн даатгал	6461400.00	5549976.02	6500200.00	6350976.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3231500.00	2906810.52	3250200.00	3232938.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3231500.00	2502777.42	3250200.00	3044418.11
210205	Эрүүл мэндийн даатгал	12926500.00	10631099.48	13000500.00	12137151.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51742200.00	48076754.00	56242200.00	52748421.00
210301	Гэрэл, цахилгаан	8700000.00	6464065.00	11400000.00	8627069.00
210302	Түлш, халаалт	35242200.00	35242133.00	35242200.00	35242200.00
210303	Цэвэр, бохир ус	7800000.00	6370556.00	9600000.00	8879152.00
2105	Нормативт зардал	88974400.00	75781050.00	82461700.00	80040940.00
210502	Хоол, хүнс	88974400.00	75781050.00	82461700.00	80040940.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9800000.00	9800000.00	20000000.00	9000000.00
210604	Урсгал засвар	9800000.00	9800000.00	20000000.00	9000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	3382100.00	1316000.00	4369300.00	4369300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3382100.00	1316000.00	4369300.00	4369300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38015400.00	35302700.00	32667100.00	31908300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29614000.00	26901300.00	24595300.00	23836500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8401400.00	8401400.00	8071800.00	8071800.00

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16708300.00	20373746.00	4024000.00	7517779.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00	3493779.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	0.0	0.00	3493779.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16708300.00	16708300.00	4024000.00	4024000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16708300.0	16708300.0	4024000.00	4024000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	75954405.3	0.00	184602894.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	184602894.9	0.00	37254536.10
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.0	256.0	0.00	256.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	25.00	0.00	25.00
620001	Удирдах ажилтан	0.0	1.0	0.00	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	0.0	15.0	0.00	15.0
620003	Үйлчлэх ажилтан	0.0	9.0	0.00	9.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.00	230.00	0.00	230.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУ	0.00	230.00	0.00	230.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	0.0	230.0	0.00	230.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4106.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн.

Алдаа: ХАОАТ-ын урд оны үлдэгдэл 167.8 мянган төгрөгийг аудитын явцад залруулсан.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тавигдаагүй.

3.2 Албан шаардлага Аудитаар 2435,6 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн. Үүнд:

Илрүүлэлт1

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн Б/46 дугаар тушаалаар цэцэрлэгийн нягтлан бодогчид 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 1,241.7 мянган төгрөгийн балансын урамшууллыг олгосон байна.

Шийдвэрлэлт:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт2

Цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг Засгийн газрын 2024 оны "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 237 дугаар тогтоолд заасан хэмжээнээс 313,7 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Шийдвэрлэлт:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх"; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2024 оны "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тогтоолын заалтуудыг зөрчсөн, СТА-ын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХАОАТ-ын урд оны үлдэгдэл 167836.86 төгрөгийг жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад тусгаагүй	1	167.8	1	167.8	1		1	167.8				
Дүн	1	167.8	1	167.8	1		1	167.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Балансын урамшуулал олгосон	1	2121,9			1	2121,9						

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Гуравдугаар Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн хоолны нормативт зардлыг дутуу олгосон байна.	1	313,7			1	313,7						
	1	2435,6			1	2435,6	0	0	0	0	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 оны 01 дүгээр сарын 26